

СТАТИСТИКИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

1997 оны 6 дугаар сарын 5-ны өдөр

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
СТАТИСТИКИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 1997 оны 6 дугаар сарын 5-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, статистикийн байгууллага, мэдээлэгчийн бүрэн эрхийг тогтоож, тэдгээрийн хооронд болон хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.	20 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын статистикийн мэдээллийн талаархи бүрэн эрх Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/нутаг дэвсгэртээ байгаа статистикийн мэдээлэгчдээс статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргуулан авч нэгтгэх, судалгаа, дүгнэлт хийж ашиглах, албан ёсны статистикийн мэдээллийг хугацаанд нь зохих дээд шатны байгууллагад өгөх 2/Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах; 3/засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийнхээ удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор, захиргааны статистикийн мэдээллийг бусад мэдээлэлтэй давхардуулахгүйгээр статистикийн байгууллагын зөвшөөрснөөр авах, мэдээллийн санг бий болгох.